



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/С

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.18, 17 дугаар зүйлийн 17.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын 2017 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Г.Лхагвахатан, Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол хариуцсан мэргэжилтэн Г.Уянга, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга С.Мөнхцэцэг, Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн Я.Батбилэгт нарыг томилсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын 2017 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг холбогдох журмын дагуу дүгнэж 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ТАНБЯМБА